



Accountants &
business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъян гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979
Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref: 01/MD/23/08152022/BP

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид “МАНДАЛ ДААТГАЛ” ХК (цаашид “Компани” гэх) –ийн 2022 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компанийн хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчмытай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайллагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2023 оны 02 дугаар сарын 15

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2021	2022	(төгрөгийн)
ХӨРӨНГӨ				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө				
Бэлэн мөнгө	2	3,867,629	347,427,629	
Харилцахад байгаа мөнгө	2	3,683,532,762	690,237,590	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн		3,687,400,392	1,037,665,220	
Даатгалын авлага				
Даатгалын хураамжийн авлага	3	6,830,235,147	8,436,032,666	
Буруутай этгээдээс авах авлага	3	146,689,341	104,498,149	
Давхар даатгалаас авах авлага	3	529,155,504	18,733,594	
Даатгалын авлагын дүн		7,506,079,992	8,559,264,408	
Бусад санхүүгийн хөрөнгө				
Бусад авлага	4	41,692,213	82,680,853	
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн		41,692,213	82,680,853	
Бусад санхүүгийн бус хөрөнгө				
НДШ авлага, бусад татварын авлага	5	396,664	27,642,182	
Хойшлогдсон татварын хөрөнгө	5	-	79,749,584	
Бараа материал	7	142,781,949	204,497,515	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6	746,569,342	1,190,139,203	
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн		889,747,955	1,502,028,484	
Хөрөнгө оруулалт				
Хадгаламж, хадгаламжийн сертификат	8	8,672,140,406	4,507,472,603	
Үнэт цаас	9	25,918,076,508	34,366,134,849	
Хөрөнгө оруулалтын дүн		34,590,216,914	38,873,607,451	
Даатгалын хөрөнгө				
Хойшлогдсон давхар даатгалын хураамж	11	9,043,414,221	19,471,750,230	
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг	11	310,254,114	279,558,073	
Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэлийн зардал	11	996,001,397	1,473,530,741	
Даатгалын хөрөнгийн дүн		10,349,669,733	21,224,839,044	
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	12	1,300,408,835	2,111,575,950	
Биет бус хөрөнгө /Цэвэр/	13	261,972,444	164,173,917	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		58,627,188,479	73,555,835,327	

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайллангийн салшгүй хэсэг болно.

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2021	2022 (төгрөгөөр)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын өглөг			
Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	14	132,929,788	247,949,005
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	14	212,901,117	309,515,396
Давхар даатгагчид өгөх өглөг	14	3,747,174,793	5,767,389,742
Даатгалын өглөгийн дүн		4,093,005,699	6,324,854,143
Бусад санхүүгийн өр төлбөр			
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	15	193,672,222	235,354,665
Ногдол ашгийн өглөг	16	19,073,518	19,073,518
Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн		212,745,740	254,428,184
Бусад санхүүгийн бус өр төлбөр			
Цалингийн өглөг	18	169,500,000	1,440,617
НДШ-ийн өглөг	18	1,359,419	249,736
ААНОАТатварын өглөг	17	130,670,048	453,435,464
ХХОАТатварын өглөг	17	96,046,882	160,311,962
Урьдчилж орсон орлого	18	773,307,088	756,530,138
Бусад санхүүгийн бус өр төлбөр	18	552,520,692	331,807,714
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн		1,723,404,130	1,703,775,630
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	19	17,797,291,488	29,576,311,173
Нөхөн төлбөрийн нөөц сан			
Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	20	2,062,732,279	1,883,811,308
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	20	2,370,017,324	1,587,105,285
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	20	1,353,611,273	1,868,158,053
Тусгай нөөц сан	20	1,256,290,011	1,256,290,011
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн		7,042,650,888	6,595,364,657
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		30,869,097,945	44,454,733,786
ЭЗДИЙН ӨМЧ			
Эзэмшигчдийн өмч	24	6,243,016,000	6,243,016,000
Нэмж төлөгдсөн капитал	26	4,441,895,708	4,441,895,708
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25	1,187,291,346	318,137,187
Хуримтлагдсан ашиг, алдагдал	27	15,885,887,480	18,098,052,646
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		27,758,090,535	29,101,101,541
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		58,627,188,479	73,555,835,327

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2021	2022	(төгрөгөөр)
Даатгалын үйл ажиллагаа				
Даатгалын хураамжийн нийт орлого	28	35,614,682,559	69,687,366,821	
Даатгалын хураамжийн буцаалт	28	(1,217,596,438)	(1,909,141,471)	
Давхар даатгалын хураамжийн зардал	28	(15,730,123,355)	(45,816,256,714)	
Даатгалын хураамжийн цэвэр орлого		18,666,962,766	21,961,968,636	
Орлогод тооцогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	28	(3,573,794,005)	11,779,019,684	
Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	28	3,221,319,464	10,428,336,009	
Орлогод тооцсон хураамж		19,019,437,307	20,611,284,961	
Нийт нөхөн төлбөрийн зардал	28	8,150,304,062	11,062,366,683	
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	28	1,132,089,182	1,260,840,412	
Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр	28	161,533,403	127,587,941	
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		6,856,681,478	9,673,938,330	
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт	28	302,849,461	(961,833,011)	
Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	28	457,609,484	30,696,041	
Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт	28	318,044,069	514,546,780	
Зардалд тооцсон нөхөн төлбөр		7,935,184,491	9,257,348,140	
Даатгалын гэрээний зардал	29	(1,858,376,263)	(2,564,169,466)	
Давхар даатгалын шимтгэлийн орлого	30	207,256,940	451,173,202	
Хөрөнгө оруулалтын орлого	31	5,009,598,756	4,884,880,663	
Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)		14,442,732,250	14,125,821,220	
Эрхийн шимтгэлийн орлого	31	10,389,588	8,762,989	
Бусад орлого	32	97,129,488	48,793,705	
Ерөнхий ба удирдлагын зардал	35	(7,269,853,263)	(8,729,319,772)	
Борлуулалт, маркетингийн зардал	36	(937,145,506)	(892,135,263)	
Санхүүгийн зардал	38	(100,294,497)	(51,449,043)	
Бусад зардал	39	(40,094,152)	(102,305,585)	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	33	80,098,800	9,651,956	
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	34	18,838,942	60,866,753	
Бусад ашиг (алдагдал)		(8,140,930,600)	(9,647,134,259)	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		6,301,801,651	4,478,686,961	
Орлогын татварын зардал	40	693,810,729	394,280,112	
Татварын дараах ашиг (алдагдал)		5,607,990,921	4,084,406,849	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		5,607,990,921	4,084,406,849	
Дахин үнэлгээний нэмэгдэл	25	1,334,439,928	318,137,187	
Орлогын нийт дүн		6,942,430,849	4,402,544,035	

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуриатлагдан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,243,016,000	4,441,895,708	(147,148,582)	12,116,427,616	22,654,190,742
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	34,373,742	34,373,742
Залруулсан үлдэгдэл	6,243,016,000	4,441,895,708	(147,148,582)	12,150,801,358	22,688,564,484
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,607,990,921	5,607,990,921
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	1,334,439,928	-	1,334,439,928
Зарласан ногдол ашиг	-	-	-	1,872,904,800	1,872,904,800
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,243,016,000	4,441,895,708	1,187,291,346	15,885,887,479	27,758,090,533
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,872,241,682.41)	(1,872,241,682)
Залруулсан үлдэгдэл	6,243,016,000	4,441,895,708	1,187,291,346	15,885,887,479	25,885,848,851
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	4,084,406,848.55	4,084,406,849
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(869,154,159)	-	(869,154,159)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,243,016,000	4,441,895,708	318,137,187	18,098,052,646	29,101,101,541

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК

МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

ҮЗҮҮЛЭЛТ	2021	2022	(төгрөгээр)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	34,958,697,834	63,961,781,615	
Даатгалын хураамжийн орлого	32,595,227,512	62,466,705,549	
Давхар даатгалын нөхөн төлбөр	616,820,193	190,324,071	
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	18,294,696	
Бусад мөнгөн орлого	1,746,650,129	1,286,457,299	
Мөнгөн зарлагын дүн (-)	32,236,558,545	64,169,236,486	
Ажиллагчдад төлсөн	3,434,664,004	4,100,641,943	
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	885,080,000	1,203,155,500	
Бараа материал худалдан авахад төлсөн	346,474,243	62,802,894	
Ашиглалтын зардалд төлсөн	92,355,551	670,954,970	
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	13,495,174,411	40,904,801,778	
Нөхөн төлбөрт төлсөн	8,170,210,060	10,501,967,879	
Үүнээс: Сайн дурын даатгалын	7,248,406,998	8,598,694,069	
Албан журмын даатгалын	921,803,062	1,903,273,811	
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	347,228,672	332,930,059	
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	903,026,514	1,532,648,372	
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	-	2,794,050	
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	76,550,879	49,679,636	
Татварын байгууллагад төлсөн	1,384,055,806	602,099,165	
Даатгалын төлбөрт төлсөн	2,931,660	13,604,691	
Бусад мөнгөн зарлага	3,098,806,745	4,191,155,549	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,722,139,289	(207,454,870)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	69,901,733,199	30,755,230,329	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	247,600,000	
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	65,696,053,967	27,347,989,573	
Хүлээн авсан хүүний орлого	4,105,490,150	3,046,952,285	
Хүлээн авсан ногдол ашиг	100,189,082	112,688,471	
Мөнгөн зарлагын дүн (-)	69,266,452,358	31,503,975,827	
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	398,412,681	1,100,004,058	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	110,782,751	22,440,000	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	68,757,256,926	30,381,531,769	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	635,280,841	(748,745,498)	
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	(52,075)	-	
Валютын ханшийн зөрүү	(52,075)	-	
Мөнгөн зарлагын дүн (-)	1,900,301,565	1,693,534,804	
Санхүүгийн түрээсийн өглөт төлсөн	203,974,269	-	
Төлсөн ногдол ашиг	1,696,327,296	1,693,534,804	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,900,353,640)	(1,693,534,804)	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,457,066,491	(2,649,735,172)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,230,333,901	3,687,400,392	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,687,400,392	1,037,665,220	

Хаесаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.